



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Х.НЯМБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2022. 03. 09 № 05

Асуулт тавих тухай

Улсын Их Хурлын гишүүн миний бие Зөвшөөрлийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна. Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдээс 500 гаруй санал, хүсэлтийг ирүүлээд байгаагийн дийлэнх хувь нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас баталсан захиргааны хэм хэмжээний акттай холбоотой байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 814 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Хуулиар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд нийтээр заавал дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг батлах буюу тухайн харилцааг нарийвчилан зохицуулах эрхийг олгодог.

Захиргааны өрөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно гэж заасан бөгөөд энэхүү шийдвэрийг мөн хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 67.2 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх зохицуулалттай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдэж байгаа хичнээн хуулиар захиргааны байгууллага, албан тушаалтанд тусгайлан захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхийг олгож, үүрэгжүүлсэн талаарх мэдээлэл;

2. Хуулиар эрх олгосны дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэж, нийтээр дагаж мөрдөж буй захиргааны хэм хэмжээний актын талаарх мэдээлэл;


3. Нийтээр дагаж мөрдөж байгаа захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалт зэрэг тодорхой мэдээллийг өгнө үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ГАНХУЯГ



2022000015